

**"МОНГОЛ ШУУДАН" ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2026.04.24

№ ХТ-26/01

Улаанбаатар хот

Огноо: **2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр**

Цаг: **10:00-12:20**

Хурал болсон газар: **"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "MSE HALL" хурлын танхим**

Хурлын дарга: **Банзрагч Ганбаатар /ТУЗ-ийн хараат бус гишүүн/**

Хурлын нарын бичгийн дарга: **Д.Цэцгээ /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/**

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын тоо: **64**

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо: **96,056,510**

Хурлын ирц: **96.5%**

Хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай,
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсөв батлах тухай,

"Монгол шуудан" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 10:00 цагт "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "MSE HALL" хурлын танхимд явагдлаа. Хуралд хурлын дарга Б.Ганбаатар, ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл, ердийн гишүүн Д.Балжинням, Д.Дэлгэрмаа, О.Одбаяр хараат бус гишүүн, Ч.Амарбаатар, Д.Балдорж, Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн болон компанийн удирдлагын багийн гишүүд биечлэн оролцлоо.

Хурлын дарга Б.Ганбаатар: ХЭ-чдийн ээлжит хуралдаа хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигчид болон компанийн удирдлагын багийн хамт олонд энэ өдрийн мэнд хүргэе. "Монгол шуудан" ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 03 сарын 13-ны өдрийн 26/04 дугаар тогтоолоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар томилогдсон. Энэ дагуу хурлыг удирдан явуулж байна. Хуралдааны ирцийн мэдээллийг танилцуулна уу гэж тооллогын комиссыг урьж байна.

Хурлын бүртгэлийг 10:00 цагт хааж, тооллогын комиссын гишүүн А.Энхзул хурлын ирцийн мэдээллийг хурлын даргад мэдээллээ.

Хурлын дарга Б.Ганбаатар: Компанийн саналын эрх бүхий хувьцааны 96.5 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцож, хурлыг хүчин төгөлдөр гэж үзсэн тул хурал нээснийг мэдэгдье. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу 2 асуудал хэлэлцэж шийдвэрлэнэ. Хурлын дэгтэй холбоотой санал хүсэлт байхгүй тул хэлэлцэх асуудалтай холбоотойгоор танилцуулгууддаа оръё.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 1: Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

Хурлын дарга Б.Ганбаатар: Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн танилцуулна.

Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн: "Монгол шуудан" ХК-ийн ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл, хурлын дарга Б.Ганбаатар, ТУЗ-ийн гишүүд болон бидэнтэй байнга хамт байдаг эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. "Монгол шуудан" ХК нь IPO хийж, олон нийтийн компани болсноос хойш 10 жилийн хугацаа өнгөрч байна. Энэ удаа Монголын хөрөнгийн бирж ХК-ийн шинэчлэн тохижуулсан энэ хурлын танхимд анх удаа хуралдаж байна. Өмнө нь бид хурлаа компанийн байранд зохион байгуулдаг байсан бол хөрөнгийн зах зээлийн

хөгжил, дэд бүтцийн сайжралтай уялдан илүү боломж бүрдэж байгааг харж байна. Одоо компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулъя. Энэ удаагийн танилцуулгаар зөвхөн тоон үзүүлэлт танилцуулахаас гадна компанийн өнөөгийн нөхцөл байдал, хөгжлийн замнал, цаашдын стратегийн чиглэлийг цогцоор нь хүргэхийг зорьж байна. 2025 онд бид дунд болон урт хугацааны стратегийн хүрээнд ямар ажлууд хэрэгжүүлсэн, цаашид ямар төлөвлөгөөтэй ажиллах талаар дэлгэрэнгүй танилцуулна. Юуны өмнө компанийн онцлогийг товч дурдъя. "Монгол шуудан" ХК нь Харилцаа холбооны зохицуулах хорооноос зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулдаг бусад шуудангийн компаниудаас хэд хэдэн онцлогоор ялгардаг. 1-рт, төрийн өмчийн давамгайл оролцоотой, 2-рт, олон нийтийн нээлттэй компани юм. Ийм хэлбэрийн компаниуд харьцангуй цөөн байлаг. Түүнчлэн тус компани нь "Бүх нийтийн үйлчилгээний үүрэг"-ийг хэрэгжүүлэгч байгууллага юм. Энэ үүрэг нь Харилцаа холбооны тухай болон Шуудангийн тухай хуулиар баталгаажсан бөгөөд Монгол улсын аль ч иргэн хаана оршин сууж байгаагаас үл хамааран шуудангийн үйлчилгээ авах эрхтэй байдаг. Уг үүргийг Монгол улсын Засгийн газрын нэрийн өмнөөс "Монгол шуудан" ХК хэрэгжүүлдэг бөгөөд энэ хүрээнд бид 21 аймаг, 330 сум, 1600 гаруй багт хүрч үйлчилж байна. 1963 оноос хойш энэхүү тасралтгүй хэрэгжүүлж ирсэн нь компанийн хувьд стратегийн ач холбогдол бүхий дэд бүтцийн байгууллага гэдгийг илэрхийлдэг.

- Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн компанийн 2025 оны тайланг дэлгэрэнгүйгээр танилцууллаа.

Хурлын дарга Б.Ганбаатар: Гүйцэтгэх захирал Г.Тэлмэнд баярлалаа. 2025 онд "Монгол шуудан" ХК-ийн хамт олны хэрэгжүүлсэн ажлын товч танилцуулгыг сонслоо. Дэлгэрэнгүй мэдээлэл авах боломж нээлттэй байгааг онцлон тэмдэглэж байна. Тус компани ирээдүйн хөгжлийнхөө хүрээнд томоохон зорилго, зорилтуудыг тодорхойлон ажиллаж байна. Үүнд технологид суурилсан шуудангийн үйлчилгээг хөгжүүлэх, үндэсний хэмжээний шуудан, логистикийн цогц бүтэц бүрдүүлэх, мөн хил дамнасан цахим худалдааны үйлчилгээг өргөжүүлэх зэрэг стратегийн чиглэлүүд багтаж байна. Монгол улсын өнцөг булан бүрд ажиллаж буй нийт ажилтан, албан хаагчдад хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, ажлын өндөр амжилт хүсье.

Дэгийн дагуу дараах танилцуулгуудыг хийлээ.

- Аудитын хорооны дарга Д.Балдорж компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн аудитын хорооны дүгнэлт болон компанийн 2024 оны ногдол ашиг тараасан тухай тайлан, 2025 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг тус тус танилцууллаа.

Хурлын дарга Б.Ганбаатар: Д.Балдорж даргад баярлалаа. Одоо ТУЗ-ийн 2025 оны тайлан, дүгнэлтийг ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл танилцуулна. Үүний дараа эхний хэлэлцэх асуудалтай холбоотойгоор асуулт, хариулт явагдана.

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. "Монгол шуудан" ХК нь нээлттэй хувьцаат компани болсноос хойших 10 дах удаагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож байна. Энэ нь миний хувьд нэр төрийн хэрэг байлаа.

- ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл ТУЗ-ийн 2025 оны тайлан, дүгнэлтийг дэлгэрэнгүйгээр танилцууллаа.

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгөөр баригдсан ялган боловсруулах төвийн барилгатай холбоотой эрсдэл үүссэн. Иймд уг асуудлаар компанийг хохиролгүй болгох чиглэлд ТУЗ-өөс дэмжлэг үзүүлж, шаардлагатай удирдамж, чиглэлээр ханган, онцгой анхаарч ажиллаж байна. Мөн хувьцаа эзэмшигчдэдээ мэдээллийг тухай бүр хүргэж ажиллана. ТУЗ-ийн зүгээс компанийн 2025 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаар дараах дүгнэлтийг

танилцуулж байна. Хөрөнгийн биржийн "А" самбарт бүртгэлтэй нээлттэй компанийн хувьд компанийн засаглал, хяналтын тогтолцоо сайн түвшинд хэрэгжиж байна гэж үзэж байна. 2025 онд тодорхой эрсдэлүүд тулгарсан ч үүний зэрэгцээ амжилттай ажлууд ч байна. Аудитын байгууллагаас өгсөн хязгаарлалттай дүгнэлт мөн тодорхой шалтгаантай. Компани дэлхийн 100 гаруй улстай хамтран шуудангийн үйлчилгээ үзүүлдэг тул жил бүр авлага, өглөгийн тооцоог олон улсын байгууллагуудтай тулган баталгаажуулахад хугацааны зөрүү гардаг онцлогтой. Цаашид олон улсын үйл ажиллагааны цар хүрээг харгалзан үзэж, олон улсын аудитын компаниар аудит хийлгэх шаардлагатай гэж үзэж байна. Үйл ажиллагааны хувьд компанийн хамт олон өмнөө тавьсан зорилго, зорилтуудаа хэрэгжүүлж, хүний нөөцийг чадваржуулах чиглэлээр олон төсөл, хөтөлбөрт ажилтнуудаа хамруулж, тодорхой үр дүнд хүрсэн байна. Хууль эрх зүй, хүний нөөц, бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр бодит ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Иймд "Монгол шуудан" ХК-ийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг ТУЗ-өөс "Сайн" гэж дүгнэснийг танилцуулж байна. Та бүхнийг энэхүү тайланг хэлэлцэн батлахыг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Хурлын дарга Б.Ганбаатар: Д.Нарангэрэл дарга болон тайлан танилцуулсан бусад гишүүддээ баярлалаа. ТУЗ-ийн хувьд компанийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр шаардлагатай үед хэдийд ч ээлжит бусаар хуралдаж, зөвлөмж, чиглэл, шийдвэрүүдийг гаргаж, идэвхтэй ажиллаж компанийг бизнесийн үйл ажиллагааг бүх талаас дэмжиж ажилладаг. Хэлэлцэх асуудалтай холбоотой танилцуулгууд дууслаа. Тайлантай холбоотойгоор асуух асуулт байвал танилцаад, хариулаад явъя.

Хувьцаа эзэмшигч Д.Отгонболд: Нэг зүйлд шүүмжлэлтэй хандмаар байна. 2024 онтой харьцуулахад 2025 оны жилийн эцсийн цэвэр ашиг өссөн байгаа нь сайн зүйл, ТУЗ-ийн зүгээс сайн ажилласан гээд дүгнэх шиг боллоо. Санхүүгийн аудитлагдсан тайланг харахаар энэ ашгийн 82 хувь нь гадаад валютын ханш дэмжээд ороод ирсэн байна. Өөрөөр хэлбэл Монгол улсын макро орчны нөлөөллөөр орж ирсэн байна. Зардал хэмнэлттэй, ашигтай гэж харагдаж байгаа боловч орлогын дүн нь өнгөрсөн оноосоо 7.2 хувь өссөн, зардал нь 8.8 хувь өсөлттэй байна. Яагаад орлогоосоо давсан зардлын өсөлт үзүүлсэн бэ.

Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн: Д.Отгонболд хувьцаа эзэмшигчийн асуултад хариулъя. 2025 онд компанийн өмнөө тавьсан зорилтыг харах хэрэгтэй. Бид ашигт ажиллагааг хангахын зэрэгцээ бизнес өргөжилтийн суурийг тавих зорилт дэвшүүлсэн. 2023 онд компани түүхэндээ хамгийн өндөр цэвэр ашигтай ажилласан. Гэвч тэнд үндсэн үйл ажиллагааны орлого, зардал 2-ын зөрүү 1.9 тэрбум төгрөгийн алдагдалтай байсан. Өмнөх жилүүдэд компанийн орлогын гол эх үүсвэр нь транзит шуудан байсныг та бүхэн мэднэ. Тухайлбал, транзитын орлого 3.1 тэрбум төгрөгт хүрч, нийт цэвэр ашгийг бүрдүүлж, алдагдалыг нөхөж байсан. Харин 2024, 2025 онд бид үндсэн үйл ажиллагаанаасаа ашигтай ажилласан. 2024 онд 2 тэрбум төгрөгийн алдагдалтай байсан компанийг алдагдлаас гаргаж, 136 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллуулсан. 2025 онд өмнөх шиг өндөр ашиг, орлогын зорилт тавих боломж байгаагүй. Үүний оронд компанийн ирээдүйн орлогыг бий болгох, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн суурь ажлуудыг эхлүүлсэн. Үүний хүрээнд компанийн түүхэнд анх удаа 6.3 тэрбум төгрөгийн дүн бүхий хөрөнгө оруулалтын төсөл, гадаадын хөрөнгө оруулалт болон бүтээгдэхүүн хуваах гэрээг байгуулсан. Мөн компанийн орлогын тодорхой хэсэг буюу ойролцоогоор 20 хувь нь валютаас хамааралтай байдаг. Иймд валютын ханшийн эрсдэлийг оновчтой удирдах шаардлага бий. Энэ хүрээнд санхүү, төлөвлөлтийн чиг үүргийг бэхжүүлэх зорилгоор холбогдох удирдлагын томилгоог хийсэн. Өмнө нь зөвхөн НББ-ийн түвшинд үйл ажиллагаа явж байсан бол одоо мөнгөн урсгалыг үр ашигтай удирдаж, алдагдлыг бууруулах, ашиг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч байна. Сүүлийн 7-8 жилийн хугацаанд компанийн үйл ажиллагааг харахад 1000 ажилтантай боловч цалингаа хангалттай олох, цалингийн тогтвортой байдал хангалтгүй байсан. Харин 2024-2025 онд ажилтнуудын бүтээмж нэмэгдэж, үйл ажиллагаа жигдэрч эхэлсэн гэж дүгнэж байна. үүнээс гадна хүүгийн орлого болон валютын ханшийн зөрүүнээс тодорхой хэмжээний орлого бүрдэж байна. Гадаад гэрээнүүдийг ихэвчлэн ам.доллар, юаниар хийж байгаа нь ханшийн өсөлттэй холбоотой. Мэдээж тоон үзүүлэлтээр харахад шүүмжлэлтэй хандах үндэслэл бий. Гэхдээ бид 2025 онд

“ашигт ажиллагааг хангах” гэсэн үндсэн зорилтоо баримталж, бизнесийн өргөжилтийн суурийг тавихад төвлөрсөн. Энэ ажлын үр дүн шууд 2025 онд бүрэн харагдахгүй, харин дараагийн жилүүдэд илүү тод илэрнэ. Жишээлбэл, 2025 оны 12 сараас транзит шуудангийн үйлчилгээ сэргэж эхэлсэн бөгөөд одоогоор 200 гаруй машин яваад байна. Өнгөрсөн жил хийсэн ажлуудын үр нөлөө энэ жилээс бодитой гарч эхэлнэ. Мөн компанийн дотоод сэтгэлгээнд өөрчлөлт хийсэн. Орон нутгийн салбарууд байнга алдагдалтай ажилладаг гэсэн ойлголттой байсан. Компанийн бүтцийг шинэчилж, Салбар, удирдлагын газар байгуулсан. Үүний үр дүнд 21 аймгаас өмнө нь зөвхөн 2 аймаг л ашигтай ажилладаг байсан бол 2024 онд 3, 2025 онд 7 аймаг ашигтай ажилласан. Аймгуудын нийт алдагдал 2024 онд 1.2 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 790 сая төгрөг болж, 40 хувиар буурсан. 2026 оны 1-р улирлын байдлаар энэ алдагдал 130 сая болж буурсан нь эерэг үзүүлэлт юм. Мөн 330 суманд цахим ПОС төхөөрөмж суурилуулсан бөгөөд одоогоор ашиглалтыг эхлүүлэх, ажилтнуудыг сургах ажил хийгдэж байна. Түүнчлэн төр, хувийн хэвшлийн байгууллагуудын үйлчилгээг бизнесийн зарчмаар, өртөг багатайгаар хүргэх чиглэлд хамтран ажиллах боломжийг судалж, холбогдох яриа хэлэлцээрүүдийг эхлүүлээд байна. Шүүмжлэлийг бид хүлээн авч, цаашид үйл ажиллагаагаа сайжруулахад анхаарч ажиллана. Та бүхэнд дэлгэрэнгүй тайлбар өглөө. Баярлалаа.

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: Зардлын өсөлтийн талаар тайлбар хэлье. 2024, 2025 онд ажилтнуудын цалинг нэмэгдүүлэх зайлшгүй нөхцөл байдал үүссэн. Ажилчид болон ШАҮЭ-ийн хорооноос удаа дараа санал, гомдол ирүүлж байсан. Бид эдгээр саналыг харгалзан үзсэн ч цалинг огцом өндөр хувиар нэмэх боломж байгаагүй. Манай үйл ажиллагаанд хүний хүчин зүйлийн нөлөөлөл өндөр хэвээр байгаа нөхцөлд цалинг тодорхой хэмжээгээр нэмэхээс өөр аргагүй болсон. Үүнээс гадна шатахууны үнийн өсөлт зардалд нөлөөлсөн. Орлогын төлөвлөгөө биелээгүй шалтгааныг бид авч үзсэн. Тухайлбал транзит шуудангийн үйлчилгээ ОХУ-тай холбоотой геополитикийн нөхцөл байдлын улмаас бараг зогссон. Бид эхэндээ энэ үйлчилгээ 4 сарын хугацаанд сэргэнэ гэж төлөвлөж байсан ч бодит байдалд сэргээгүй. Иймд Геополитикийн нөлөөллийг бодитоор үнэлэх шаардлагатай. Мөн валютын ханшийн зөрүүний удирдлагыг оновчтой хэрэгжүүлж чадаагүй тохиолдолд алдагдал хүлээх эрсдэл үүсдэг. Ялангуяа Дэлхийн 100 гаруй улстай харилцаж, гадаад төлбөр тооцоо хийдэг компанийн хувьд валютын ханшийн эрсдэлийг зөв удирдах нь зайлшгүй чухал асуудал гэж би харж байна.

Хурлын дарга Б.Ганбаатар: Өөр асуулт байна уу.

Хувьцаа эзэмшигч Ч.Амарбаатар: Миний хувьд Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн болон удирдлагын багийг сайн ажиллаж байна гэж үнэлж байна. Би “Монгол шуудан” ХК-ийн хувьцааг худалдан авах шийдвэр дотоодын зах зээлээс илүүтэй эдийн засгийн коридорын боломжийг олж харсан. Энэ чиглэлд шуудан, логистикийн салбарт “Монгол шуудан” ХК-иас өөр ийм хэмжээний боломжийг хэрэгжүүлэх чадавхтай байгууллага байхгүй гэж үзэж, хөрөнгө оруулалт хийсэн. Өнөөдрийн байдлаар компанийн үйл ажиллагаа өөдрөг, эрэлт хэрэгцээтэй, ирээдүйтэй чиглэлд явж байгаад сэтгэл хангалуун байна. Геополитикийн нөхцөл байдал биднээс үл хамаарах хүчин зүйл боловч үүний цаана бидэнд бодит боломжууд нээгдэж байгааг зөвөөр үнэлэх шаардлагатай. Асар уудам газар нутаг, стратегийн байршлаа ашиглан хөрш орнуудтайгаа хамтран ажиллах боломжийг үр ашигтай ашиглах хэрэгтэй гэж бодож байна. Тодорхой хүндрэл, сорилтууд гарах нь зайлшгүй. Гэсэн хэдий ч чөлөөт бүсийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, бодитой ажил хэрэг болгох шаардлага байна. Энэ чиглэлд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлж, “Монгол шуудан” ХК нь ОХУ болон БНХАУ-тай хамтран, саад бэрхшээлээс үл хамааран бизнесээ өргөжүүлэх боломжтой гэж үзэж байна. Амжилттай ажиллаж буй удирдлагын багт талархал илэрхийлж, цаашдын ажилд нь өндөр амжилт хүсье.

Хурлын дарга Б.Ганбаатар: Өөр асуулт байна уу. Хэрэв байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалд орьё.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 2: ТУЗ-ийн 2025 оны зардлын төсөв батлах тухай;

Хурлын дарга Б.Ганбаатар: ТУЗ-ийн 2025 оны зардлын тайлан болон 2026 оны зардлын төсвийн мэдээллийг ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Балжинням танилцуулна.

- ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Балжинням ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг танилцууллаа.

Хурлын дарга Б.Ганбаатар: Зардлын төсөвтэй холбоотой асуулт байна уу.

Өөр асуулт, санал хүсэлт байхгүй гэснээр 11:30 цагт хурал түр завсарлалаа. Хурлын завсарлагаар Тооллогын комисс саналын хуудасны нэгтгэл хийлээ. Хурал 12:00 цагт эхэллээ.

Хурлын дарга Б.Ганбаатар: Завсарлага дууссан тул хурлыг эхлүүлэе. Тооллогын комисс саналын хуудсыг нэгтгэж дууссан тул тооллогын үр дүнд танилцуулна уу хэмээн гишүүн А.Энхзулыг урья.

- Тооллогын комиссын дарга А.Энхзул санал хураалтын дүн буюу тооллогын комиссын тогтоолыг танилцууллаа.

Хурлын дарга Б.Ганбаатар: Тооллогын комиссын даргад баярлалаа. Хурлаас гарах шийдвэрийн төслийг танилцуулъя.

- Хурлын дарга Б.Ганбаатар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрүүдийг танилцууллаа.

Хурлын дарга Б.Ганбаатар: Хуралдаа идэвхтэй оролцсон ба бүхэнд баярлалаа. Бүгдэд нь эрүүл энх, ажлын амжилт хүсье.

Хурал 12:20 цагт дууслаа.

ХУРЛЫН ДАРГА:

Б.ГАНБААТАР

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



Д.ЦЭЦГЭЭ